



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/6/СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Авлага.....	6
2.8.3 Бараа материал	7
2.8.4 Үндсэн хөрөнгө	7
2.8.5 Өр төлбөр.....	8
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	12
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

**ИХХЭТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Г.НАМУУНЗУЛ ТАНАА**

2020.03.25 № 1-6/354
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Иххэт сумын Засаг дарга Г.Намуунзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 12-аас 2020 оны 03 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 05/96 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 1,080.1 сая төгрөгийн 1 хувь буюу 10.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 22.2 сая төгрөгөөр тогтоосон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлт байхгүй байна.

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 112.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 93.4 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 0.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.8 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 14.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 24.5 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Иргэдийн Төлөөлөгчдийн хурал эхний хагас жилийн санхүүгийн тайланд 24.5 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжих орлогоор бүртгэснийг орон нутгийн төсвөөс санхүүжих орлогоор залруулсан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд наадмын талбай шинээр барих ажлын дутуу санхүүжилт 66.6 сая төгрөгийг өглөг, авлагаар бүртгэсэн.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 115.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 136.5 сая төгрөг болж 21.3 сая өссөн буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	115.2	136.5	21.3	118
Банканд байгаа бэлэн мөнгө				
Хадгаламж				
Дүн	115.2	136.5	21.3	118

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 136.5 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн 86.5 сая төгрөг, Нөхөн сэргээлтийн сангийн 34.6 сая төгрөг, Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 14.5 сая төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэмэлт санхүүжилтийн 0.5 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн 0.4 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 158.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 191.8 сая төгрөг болж, 33.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.3	0.0	-1.3
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага	15.2	0.0	-15.2
Зээлийн хүүгийн авлага	0.0	5.5	5.5
Бусад авлага	3.7	72.5	68.8
Зээлийн авлага	137.8	113.8	-24.0
Дүн	158.0	191.8	33.8

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн авлага 119.3 сая төгрөг, Эрүүл мэндийн төв эм эмнэлгийн хэрэгсэл, шатахууны нөөц 5.8 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн “Наадмын талбай шинээр барих” ажлын үлдэгдэл санхүүжилтийн авлага 66.7 сая төгрөг байна

Аудитын илрүүлэлт:

Эрүүл мэндийн төв – Тайлант оны эцэст Минжит-Алтай ХХК-д тээвэр шатахууны хэмнэлт 3.2 сая төгрөг, Төгс-Омболо ХХК-д эмийн зардал 1.4 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж авлага үүсгэсэн.

Эрүүл мэндийн төв – Тайлант хугацаанд 6.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тайлагнасан байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 185.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 242.1 сая төгрөг болж, 56.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	7.1	7.1	0
Эм боох материал	1.4	15.2	13.8
Бэлэн бүтээгдэхүүн			
Бичиг хэргийн материал	6.3	16.2	9.9
Аж ахуйн материал	140.1	169.9	29.8
Түлш шатах тослох материал			
Хүнсний материал	8.9	12.2	3.3
Мал амьтад	1.9	0.5	-1.4
Сэлбэг хэрэгсэл	4.6	5.5	0.9
Бусад хангамжийн материал	15.5	15.5	0.0
Дүн	185.8	242.1	56.3

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 3.2 сая төгрөг, Засаг даргын тамгын газар 22.0 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 97.7 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 47.3 мянган төгрөг, Соёлын төв 30.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 41.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын Тамгын газар – Сэлбэг хэрэгслийн материалыг аж ахуйн материалын дансанд бүртгэж тайлагнасан.

Хүүхдийн цэцэрлэг – Няравын бараа материалын үлдэгдлийг нягтлан бодогч баталгаажуулдаггүй, бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,118.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,595.2 сая төгрөг болж 476.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	3,273.3	3,666.0	392.7
Хуримтлагдсан элэгдэл	-46.4	-118.2	-71.8
Авто тээврийн хэрэгсэл	326.5	379.9	53.4
Хуримтлагдсан элэгдэл	-211.8	-258.5	-46.7
Машин тоног төхөөрөмж	396.9	474.3	77.4
Хуримтлагдсан элэгдэл	-272.4	-314.9	-42.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	219.2	260.9	41.7
Хуримтлагдсан элэгдэл	-147.6	-165.0	-17.4
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.1	0.1	0.0
Бусад үндсэн хөрөнгө	740.2	785.7	45.5
Хуримтлагдсан элэгдэл	-327.5	-384.9	-57.4
Дуусаагүй барилга байгууламж	0.0	94.6	94.6
Ном	33.0	39.8	6.8
Програм хангамж	4.8	5.2	0.4
Хуримтлагдсан элэгдэл	-4.8	-4.9	-0.1
Бусад биет бус хөрөнгө	135.2	135.1	-0.1
Дүн	4,118.7	4,595.2	476.5

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 103.2 сая төгрөг, балансас балансад шилжүүлэн авсан 35.0 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар 605.3 сая төгрөг нэмэгдсэн, балансас балансад шилжүүлсэн 31.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламж дансанд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Наадмын талбай шинээр барих” ажил 94.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Ерөнхий боловсролын сургууль – Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнэ болон ашиглагдах жилийг шинэчлэх.

Хүүхдийн цэцэрлэг – Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/ маягтаар үнийн дүнгээр тайлагнасан байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 47.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 66.6 сая төгрөг болж, 19.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	1.1	0.0	-1.1	100
Байгууллагад төлөх өглөг	36.5	66.6	30.1	182
Хувь хүмүүст төлөх өглөг	9.4	0.0	-9.4	100
Дүн	47.0	66.6	19.6	141

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд 66.6 сая төгрөгийн Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,541.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,109.6 сая төгрөг болж, 568.0 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/ Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ Хуримтлагдсан үр дүн Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	2,032.5	2,032.5	0.0	100
Хуримтлагдсан үр дүн Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	964.2	1,532.2	568.0	158
Хуримтлагдсан үр дүн Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	1,544.9	1,544.9	0.0	100
Дүн	4,541.6	5,109.5	568.0	112

Эх сурвалж: Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансанд өөрчлөлт ороогүй.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга хийгдээгүй.

2.9 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Иххэт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 12/05 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 30.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 52.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 171 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1.6	12.3	-10.7	768
Хадгаламжийн хүүгийн орлого	12.5	14.1	-1.6	113
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	6.3	13.5	-7.2	216
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	0.5	1.0	-0.5	200
Бууны албан татвар	1.5	1.2	0.3	80
Улсын тэмдэгтийн хураамж	1.1	1.8	-0.7	154
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны хураамж	0.3	0.3	0.0	100
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6.1	7.7	-1.6	124
Хүү торгуулийн орлого	0.5	0.1	0.4	20
Нийт дүн	30.4	52.0	-21.6	171

Үйл ажиллагааны орлого 10.7 сая төгрөгөөр давсан нь арьс шир, ноосны мөнгөний урамшууллын татвар орсноос, Хадгаламжийн хүүгийн орлого 1.7 сая төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламжийн үйлчилгээ нэмэгдсэнээс, Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 7.2 сая төгрөгөөр давсан нь хувь хүнээс төлсөн татвар нэмэгдсэнээс, Улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая төгрөгөөр давсан нь сумын Бүрдэнэ багт үйл ажиллагаа явуулдаг хүдрийн баяжуулах “Хөх бишрэлт” ХХК нь гүний худгийн 2 цооног өрөмдөх зөвшөөрлийн хураамж төлснөөс, Хог хаягдлын хураамж 1.5 сая төгрөгөөр давсан нь суманд барилгын ажил болон засварын ажил хийсэн аж ахуйн нэгж байгууллагаас төлбөр төлүүлснээс, Хүү торгуулийн орлого 0.4 сая төгрөгөөр тасарсан нь 2019 оны 1-3 сар хүртэл Олон нийтийн цагдаа ажиллаад ажлаас чөлөөлөгдсөн, дараагийн цагдаа 12 сард ажилд томилогдсоноос, Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 0.5 сая төгрөгөөр давсан нь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт өмнөх оныхоос өссөнөөс шалтгаалсан.

Бууны албан татвар 0.3 сая төгрөгөөр тасарсан нь иргэд буугаа алдсан, хураалгасан, шилжүүлсэн ч бүртгэл хийлгэж хасалт хийлгээгүй ногдуулалт хийгдсэнтэй холбоотойгоор тасарсан болно.

Орлого давсан нь төсвийн зарлага болон орлогын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх чиглэлийг Сангийн сайдаас ирүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,177.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,050.1 сая төгрөгийг урсгал зардалд, 127.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 878.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,084.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 127.5 сая төгрөг, 65.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 858.3 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 15.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,070.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 57.4 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 25.7 сая төгрөг, нийт 2,027.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 1.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0.1 сая төгрөгөөр давсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2.006.9 сая төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт дутуу хийгдсэн, мөн төсөвт байгууллагуудын зардлын зарцуулалт хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 127.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 57.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Зардлын гүйцэтгэл 59.9 сая төгрөг. Урд оны үлдэгдлийн 2.5 сая төгрөгийг зарцуулсан. 67.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон.

Нэмэлт төсөв: Засаг даргын Тамгын газар 65.0 сая төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 1.8 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 2.0 сая төгрөг, Соёлын төв 2.9 сая төгрөг нийт 71.7 сая төгрөг төвлөрснөөс 71.5 сая төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 126 мэдээллийг хугацаанд нь, 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, бусад гэх мат мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	470,041.9	581,166.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	115,192.3	136,480.6
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	115,192.3	136,480.6
31210	Төгрөг	115,192.3	136,480.6
31211	Төрийн сангийн харилцах	115,192.3	136,480.6
33	АВЛАГА	158,072.9	191,886.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,395.2	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,204.8	-
33400	Зээлийн хүүгийн авлага	-	5,539.0
33500	Бусад авлага	3,670.5	72,531.6
33510	Байгууллагаас авах авлага	3,670.5	72,531.6
33600	Зээлийн авлага	137,802.5	113,815.4
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	137,802.5	113,815.4
33612	Хувь хүмүүст олгосон зээл	137,802.5	113,815.4
35	БАРАА МАТЕРИАЛ	185,876.7	242,189.7
35100	Түүхий эд материал	8,548.6	22,379.8
35110	Тусгай зориулалттай материал	7,110.5	7,110.5
35130	Эм боох материал	1,438.2	15,269.4
35400	Хангамжийн материал	175,394.4	219,239.8
35410	Бичиг хэргийн материал	6,322.0	16,248.9
35420	Аж ахуйн материал	140,144.4	169,956.2
35430	Сэлбэг хэрэгсэл	4,633.6	5,431.1
35440	Түлш, шатах тослох материал	0.0	0.0
35460	Хүнсний материал	8,828.5	12,137.8
35470	Бусад хангамжийн материал	15,465.8	15,465.8
35600	Мал амьтад	1,933.7	570.0
36	НӨӨЦИЙН БАРАА	10,900.0	10,609.9
36300	Тэжээлийн нөөц	3,900.0	3,609.9
36600	Бусад нөөц	7,000.0	7,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,118,723.1	4,595,190.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,118,723.1	4,595,190.4
39200	Биет хөрөнгө	3,983,518.2	4,459,716.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,273,376.9	3,666,001.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,469.9)	(118,180.2)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	326,516.8	379,786.8
39204	Хуримтлагдсан элэгдэл	(211,823.7)	(258,424.1)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	396,935.4	474,233.7
39206	Хуримтлагдсан элэгдэл	(272,460.7)	(314,897.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	219,206.3	260,862.3
39208	Хуримтлагдсан элэгдэл	(147,651.1)	(165,044.1)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	185.6	185.6
39214	Бусад үндсэн хөрөнгө	740,213.1	785,733.9
39215	Хуримтлагдсан элэгдэл	(327,523.2)	(384,967.5)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	94,574.2
39217	Ном	33,012.6	39,851.3
39300	Биет бус хөрөнгө	135,204.9	135,473.5

39301	Програм хангамж	4,870.0	5,200.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,847.1)	(4,908.5)
39303	Бусад биет бус хөрөнгө	135,182.0	135,182.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,588,765.0	5,176,356.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	47,087.9	66,673.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,087.9	66,673.2
41300	Өглөг	47,087.9	66,673.2
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,161.7	-
41360	Бусад өглөг	45,926.1	66,673.2
41361	Байгууллагад төлөх өглөг	36,588.2	66,673.2
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,338.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,541,677.1	5,109,683.5
51	Засгийн газрын хувь оролцоо	4,541,677.1	5,109,683.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,032,553.6	2,032,553.6
51200	Хуримтлагдсан үр дүн	964,143.6	1,532,149.9
